



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/83

Сангиндалай

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 7-р багийн нутаг дэвсгэрт Хийд 3-313 тоот хаягт байршилтай Соёлын төв (РД:9034749)-ийн төрийн үйлчилгээний зориулалттай 1257м.кв (0.1 га) газрыг Засаг даргын Тамгын газар (РД9033629)-т хүүхдийн ордны зориулалтаар 9 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх шилжүүлсэн байгууллагын холбогдох материалыг бүрдүүлэн газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгохыг газрын даамал (Э.Ууганцэцэг)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/44 дугаар захирамжийн Соёлын төвд холбогдох хэсгийг, мөн газар эзэмших 0000077743 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



О.ВАЗАРРАГЧАА

482302165